

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

Аудитын гэрчилгээ	2
Аудитын тайлан.....	4
2.1 Оршил.....	4
2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	4
2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	5
2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	5
2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд.....	5
2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	6
2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12 Шилэн дансны мэдээлэл	8
2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт.....	8
2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл	8
Менежментийн захидал	9
Аудит хийсэн санхүүгийн тайлан	12
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	12
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	13
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	15
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	17
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	18
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	19
Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ХХААХҮЯ	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ ТӨРИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ
Т.ЖАМБАЛЦЭРЭН ТАНАА

2020.02.21 № 06/587
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовн баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.1 Оршил

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Т.Жамбалцэрэн Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэн орлогыг бодитой төлөвлөн, бүрдүүлж ажиллах, цалин, нэмэгдэл урамшууллыг холбогдох журам, шийдвэрийн дагуу үнэн зөв тооцож олгох, хоорондын тооцоог бүртгэл тайланд бүрэн тусгах, анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгахгүй байх зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 27-ноос 2020 оны 2 дугаар сарын 20-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын аудитор Э.Энхбаатар, гэрээт аудитор Н.Нямсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 01/306 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3 Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь “Салбарын бодлогыг оновчтой тодорхойлж хэрэгжүүлэх замаар түүхий эдийн нөөцийг зохистой ашиглах, импортыг орлох, экспортын

баримжаатай бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үнэ цэнийн сүлжээг хөгжүүлэх, үйлдвэрлэлийн орлого, бүтээмжийг өсгөн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн салбарын эдийн засгийн өсөлтийг тогтвортой нэмэгдүүлэх, хүн амыг эрүүл, баталгаат, шим тэжээллэг хүнс, эрүүл ахуй, хэрэглээний шаардлага хангасан хувцас, хэрэгслээр хангах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.” гэсэн ажиллагааны зорилгын хүрээнд стратегийн зорилтууд дэвшүүлэн ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Тус байгууллага нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Acolous” программ хангамж ашигладаг байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 18 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2018 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшнийг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 3,931,712.1 мянган төгрөгөөс тооцон 78,634.2 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд 2019 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,852,739.5 мянган төгрөгөөс 2 хувиар тооцож материаллаг байдлын түвшнийг 117,054.8 мянган төгрөгөөр тогтоолоо.

2.8 Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1,833,469.2 мянган төгрөгөөр буюу 22.5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	-	10,000.0	10,000.0
Авлага	-	312,882.8	312,882.8
Урьдчилгаа	-	3,402.5	3,402.5
Бараа материал	153,130.2	494,933.6	341,803.4
Үндсэн хөрөнгө	8,001,525.6	9,166,906.1	1,165,380.5
Нийт хөрөнгө	8,154,655.8	9,988,125.0	1,833,469.2
Засгийн газрын хувь оролцоо	8,154,655.8	9,988,125.0	1,833,469.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	8,154,655.8	9,988,125.0	1,833,469.2

Өмнөх оны үзүүлэлтээс авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн дансанд материаллаг хэмжээний өөрчлөлт гарсан байна. Тухайлбал:

Олон улсын AFASI байгууллагаас газар тариалан, хүнсний чиглэлээр 2-3 жилийн хугацаатай хэрэгжүүлж буй 5 төслийн зарцуулагдаагүй үлдэгдэл 312,882.8 мянган төгрөгийг оны эцэст улсын төсөвт төвлөрүүлсэн дүнгээр авлага үүсгэн бүртгэсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 341,803.4 мянган төгрөгөөр өссөн нь “Мал хамгаалах сан” татан буугдсантай холбоотой бараа материалын үлдэгдлийг балансаас баланст үнэ төлбөргүй шилжүүлэн авснаас шалтгаалсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,165,380.5 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд хөрөнгө оруулалтаар 75,060.8 мянган төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, барилгын дээвэрт 146,078.8 мянган төгрөгийн их засвар хийж капиталжуулсан, Мал хамгаалах сан, Мал эмнэлгийн ерөнхий газар, Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлд шинжлэх ухааны ололт нэвтрүүлэх төвөөс балансаас баланст 1,888,461.8 мянган төгрөгийн хөрөнгө шилжиж ирсэн, нийт 2,109,601.4 мянган төгрөгөөр хөрөнгө нэмэгдэж, аудитын зөвлөмжийн дагуу 110,232.0 мянган төгрөгийн залруулга хийсэн зэргээс шалтгаалсан байна.

ТӨБЗГ-ын 2019 оны 623 дугаар тогтоолын дагуу 1,182,242.2 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг акталж, ШУТИС-ийн харьяа Хөнгөн үйлдвэрийн лаборатори, Хүнсний коллежид 585,722.6 мянган төгрөгийн хөрөнгийг шилжүүлжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 9,988,125.0 мянган төгрөг болж 1,883,469.2 мянган төгрөгөөр өссөн нь Мал хамгаалах сан болон бусад байгууллагаас үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй барилга байгууламж, авто тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга болон бусад биет бус хөрөнгийг шилжүүлэн авснаас шалтгаалжээ.

2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 4,160,866.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж, нийт 4,113,366.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 47,500.0 мянган төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 4,113,366.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 17,160.2 мянган төгрөг нийт 4,130,526.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж ажилласан байна. Үндсэн үйл ажиллагааны орлого 30,339.9 мянган төгрөгөөр тасарсан байна. Гүйцэтгэлээр урсгал зардалд 4,071,136.9 мянган төгрөгийг зарцуулж үлдэгдэл 59,389.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 97.8 хувьтай байгаа нь тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн мэдээллийн технологийн шинэчлэлт, хөгжүүлэлтийн ажил бүрэн хийгдээгүй, валютын ханшийн өөрчлөлтөөс олон улсын байгууллагад төлөх гишүүнчлэлийн татвар буурсан, 1 ажилтны тэтгэвэрт гарах хугацаа тодорхой шалтгааны улмаас хойшлогдсоноос тэтгэмжийг олгоогүй, дотоод албан томилолтын зардал дутуу зарцуулагдсан зэрэгтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилтээр Олон улсын AFASI байгууллагаас газар тариалан, хүнсний чиглэлээр 2-3 жилийн хугацаатай 5 төсөл хэрэгжүүлэхээр 326,684.7 мянган, НҮБ-ийн хүүхдийн сангаас 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, Засгийн газрын нөөц сангаас улсын аварга малчин, тариаланчдад олгох шагналын санхүүжилтэд 239,000.0 мянган, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 20,000.0 мянга, нийт 595,684.7 мянган төгрөгийн санхүүжилт авч 283,195.9 мянган төгрөгийг зарцуулж, зарцуулагдаагүй үлдэгдлээс 302,488.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, 10,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.10 Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 18 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн гүйцэтгэх үе шатанд 18 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн баталгаажуулсан болно.

Аудитаар нийт 703,732.7 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 669,228.7 мянган төгрөгийн 3 алдааг санхүүгийн тайланд залруулж, 34,504.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө. Үүнд:

Завсрын аудитаар илэрсэн дараах асуудлуудад өгсөн албан шаардлага, зөвлөмжийг хэрэгжүүлэн, алдааг залруулсан байна. Тухайлбал:

1. Үндсэн хөрөнгөд бүртгэлтэй 605.0 мянган төгрөгийн цэвэр ус, халуун усны шугам, ажилчдын орон сууцны доор байрлах гарааш зэрэг хөрөнгийг дахин үнэлж бүртгээгүй 110,232.0 мянган төгрөгийн зөрчил гарсан нь Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ын мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд залруулга хийсэн;

2. Тус яамны зарим үндсэн хөрөнгийг түүвэрлэн тооллого хийхэд 212,614.8 мянган төгрөгийн Үслэг эдлэлийн ширхэгийн голч тодорхойлох тоног төхөөрөмж, 223,506.7 мянган төгрөгийн Биеийн скайнерийн тоног төхөөрөмж нь ШУТИС -ийн харьяа Хөнгөн үйлдвэрийн лаборатори, Хүнсний коллежид тус тус ашиглагдаж байна. Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйл. Төрийн байгууллага, албан газрын эд хөрөнгийн эрх 2-т "Төрийн байгууллага, албан газар ... нь өөрт олгогдсон эд хөрөнгийн талаар дараах эрх, үүрэгтэй", 1-д "өөрт олгогдсон эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үйл ажиллагааныхаа зорилгод нийцүүлэн зориулалтын дагуу эзэмшиж, ашиглах" заалтыг хэрэгжүүлээгүй төсвийн захирагч нь хөрөнгийн үр ашгийг хүртэх, чанар байдалд хяналт тавих боломжийг хангаж ажиллаагүй.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 623 дугаар тогтоолоор хөрөнгийг ашиглаж байгаа байгууллагуудад балансаас баланст шилжүүлж бүртгэлээс хассан;

3. Бараа материалын дансанд нэг бүр нь 1595 төгрөгийн үнэтэй 76970 ширхэг нийт 122,767.2 мянган төгрөгийн үнэтэй Жижиг, дунд үйлдвэр эрхлэгч иргэний гэрчилгээ үнэ цэнээ алдаж, цаашид ашиглагдахгүй болсон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн

6.4.1-д "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: ХХААХҮС-ын 2019 оны А-454 тушаалаар дээрх гэрчилгээг акталж данс бүртгэлээс хассан.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Ажлаас чөлөөлөгдсөн 4 ажилтанд Шүүхийн шийдвэрийн дагуу олгох ажилгүй байсан хугацааны цалин, нийгмийн даатгалын шимтгэл 58,679.5 мянган төгрөгийн нөхөн олговрыг өгсөн зөрчилд буруутай албан тушаалтнаар төлүүлэх, албан шаардлагыг холбогдох дээд шатны төсвийг захирагчийн дотоод аудитын нэгжид тавьж шийдвэрлүүлэхээр болов.

2.12 Шилэн дансны мэдээлэл

Төсвийн шууд захирагч нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан 210 мэдээллийг хугацаанд нь 25 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13 Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчлийг арилгах 2 зөвлөмж хүргүүлснээс 1 зөвлөмжийг хэрэгжүүлж, МХЕГ-аас ашиглах боломжгүй гэсэн дүгнэлт гарсан учир "Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй ажилчдын орон сууцыг зориулалтын дагуу ашиглаагүй, тус барилгад хөрөнгийн дахин үнэлгээ хийлгэх" зөвлөмж хэрэгжих боломжгүй байна.

2.14 Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга, аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Орлогын данстай холбоотой асуудал

3.1.1 Илрүүлэлт:

Үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг 30,339.9 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх;” заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

3.1.2 Эрсдэл:

Орлогын төлөвлөгөө тасрах, холбогдох хууль, тогтоомжийг мөрдөж ажиллаагүй байх;

3.1.3 Өгсөн зөвлөмж:

Төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бодитой төлөвлөж, бүрдүүлж ажиллах;

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хариу ирүүлсэн.

Зардлын данстай холбоотой асуудал

3.2.1 Илрүүлэлт:

Ажилтанд ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг тушаалд заасан хувь хэмжээнээс 342.4 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон нь Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ыг зөрчиж байна.

3.2.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах, тушаал шийдвэрийг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.2.3 Өгсөн зөвлөмж:

Цалин, нэмэгдэл урамшууллыг журам, тушаал, шийдвэрийн дагуу үнэн зөв тооцож олгож байх;

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хариу ирүүлсэн;

Балансын данстай холбоотой асуудал

3.3.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаарх 210.0 мянган төгрөгийн авлагыг 2018 оны санхүүгийн тайланд тусгаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ", 14.4.2-т "Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т "Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Холбогдох хууль зөрчигдөх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.3.3 Өгсөн зөвлөмж:

Хоорондын тооцоог санхүүгийн тайланд бүрэн тусгаж байх;

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хариу ирүүлсэн;

Балансын данстай холбоотой асуудал

3.4.1 Илрүүлэлт:

Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 44,655.6 мянган төгрөгийн өртөгтэй орон сууцны барилгын газрыг үнэлж бүртгээгүй нь Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалаар баталсан "Үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, бүртгэлийг нягтлан бодох бүртгэлийн дансанд тусгах аргачлал"-ын 5 дугаар зүйл Дахин үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд тусгах" гэсэн заалтыг хэрэгжүүлээгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх, санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх;

3.4.3 Өгсөн зөвлөмж:

Холбогдох журам, аргачлалын дагуу газрыг үнэлж бүртгэлд тусгах;

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хариу ирүүлсэн.

Балансын данстай холбоотой асуудал

3.5.1 Илрүүлэлт:

Харилцах данснаас анхан шатны бүрдэл дутуу 3,821.7 мянган төгрөгийн баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Холбогдох хууль, журам, зааврыг мөрдөж ажиллаагүй байх;

3.5.3 Өгсөн зөвлөмж:

Анхан шатны баримтгүй, бүрдэл дутуу баримтаар ажил гүйлгээ хийж, данс бүртгэлд тусгахгүй байх;

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үйлчлүүлэгч байгууллагын удирдлагууд хүлээн зөвшөөрч зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах хариу ирүүлсэн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	153,130,163.36	821,218,914.79
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	10,000,000.00
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	10,000,000.00
33	АВЛАГА	-	312,882,809.20
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	-	747,601.72
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	302,488,807.48
335	Бусад авлага	-	9,646,400.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	-	9,646,400.00
34	УРЬДЧИЛГАА	-	3,402,514.00
34600	Урьдчилж гарсан зардал	-	3,402,514.00
35	БАРАА МАТЕРИАЛ	153,130,163.36	494,933,591.59
351	Түүхий эд материал	-	4,921,347.83
35110	Тусгай зориулалттай материал	-	4,921,347.83
35300	Бэлэн бүтээгдэхүүн	-	447,250,000.00
354	Хангамжийн материал	153,130,163.36	42,762,243.76
35410	Бичиг хэргийн материал	1,676,800.00	6,171,147.00
35420	Аж ахуйн материал	130,830,450.00	1,711,760.00
35440	Түлш, шатах тослох материал	1,119,911.00	7,277,216.00
35470	Бусад хангамжийн материал	19,503,002.36	27,602,120.76
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	8,001,525,614.29	9,166,906,107.59
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	8,001,525,614.29	9,166,906,107.59
392	Биет хөрөнгө	7,732,866,457.36	8,815,080,127.59
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,099,372,284.49	8,711,123,084.97
39202	Хуримтлагдсан элэгдэл	(858,133,782.99)	(239,663,066.75)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	309,925,242.78	344,271,309.78
39204	Хуримтлагдсан элэгдэл	(309,925,242.78)	(344,271,309.78)
39205	Машин тоног төхөөрөмж	1,366,021,671.16	859,290,166.68
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,091,927,114.84)	(699,851,449.47)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	825,364,970.58	854,020,907.58
39208	Хуримтлагдсан элэгдэл	(620,331,571.26)	(684,435,662.13)
39214	Бусад үндсэн хөрөнгө	20,000,000.00	25,087,504.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(7,499,999.78)	(10,491,357.29)
393	Биет бус хөрөнгө	268,659,156.93	351,825,980.00
39301	Программ хангамж	112,060,000.00	329,562,750.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(91,660,000.00)	(307,242,750.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	268,248,980.00	329,505,980.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(19,989,823.07)	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	8,154,655,777.65	9,988,125,022.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,154,655,777.65	9,988,125,022.38
51	Засгийн газрын хувь оролцоо	8,154,655,777.65	9,988,125,022.38
51101	Засгийн газрын оруулсан капитал	6,518,504,470.95	6,518,504,470.95
512	Хуримтлагдсан үр дүн	(314,662,934.19)	1,340,743,898.55
51210	Өмнөх үеийн үр дүн	(314,662,934.19)	389,874,999.64
51220	Тайлант үеийн үр дүн	-	950,868,898.90
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,950,814,240.89	2,128,876,652.89
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	8,154,655,777.65	9,988,125,022.38

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	3,797,648,764.79	6,803,608,401.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,200,679.19	2,103,375,075.96
120	Нийтлэг татварын бус орлого	203,200,679.19	2,103,375,075.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	203,200,679.19	2,103,375,075.96
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,680,270.30	17,160,200.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	192,520,408.89	2,086,214,875.96
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,594,448,085.60	4,700,233,325.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,343,428,100.00	4,113,366,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,343,428,100.00	4,113,366,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	586,867,225.48
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	336,684,725.48
131103	ЗГНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	230,182,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	20,000,000.00
1330	Төсвийн захирагчдаас	245,018,597.00	-
133005	Төсвийн ерөнхийлөн захирагч хооронд хийсэн санхүүжилт	245,018,597.00	-
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	6,001,388.60	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	6,001,388.60	-
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,735,869,918.39	4,931,181,001.94
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,735,869,918.39	4,931,181,001.94
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,996,068,769.40	3,898,402,598.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,320,184,721.31	1,725,902,500.00
210101	Үндсэн цалин	893,666,721.31	1,093,203,900.00
210102	Нэмэгдэл	258,078,700.00	463,639,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	168,439,300.00	169,059,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,306,200.00	215,737,800.01
210201	Тэтгэврийн даатгал	106,404,800.00	146,701,700.01
210202	Тэтгэмжийн даатгал	12,975,400.00	17,259,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,380,300.00	13,807,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,595,000.00	3,451,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,950,700.00	34,518,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233,195,800.00	228,795,800.00
210301	Гэрэл, цахилгаан	94,932,300.00	103,897,300.00
210302	Түлш, халаалт	105,397,300.00	92,032,300.00
210303	Цэвэр, бохир ус	32,866,200.00	32,866,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	75,965,663.00	92,469,936.53
210401	Бичиг хэрэг	23,459,119.00	31,766,483.60
210402	Тээвэр, шатахуун	25,953,184.00	32,426,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	26,553,360.00	28,277,452.93
2105	Нормативт зардал	300.00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	300.00	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	15,884,800.00	73,377,616.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	18,700.00	-
210604	Урсгал засвар	15,866,100.00	73,377,616.00
2107	Томилолт, зочны зардал	34,093,625.00	79,587,676.00
210701	Гадаад албан томилолт	-	6,522,968.00
210702	Дотоод албан томилолт	34,093,625.00	73,064,708.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	395,585,229.33	574,342,310.27

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	386,962,529.33	564,031,871.27
210803	Даатгалын үйлчилгээ	4,895,100.00	4,926,934.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,698,900.00	933,805.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	157,500.00	136,100.00
210807	Газрын төлбөр	1,871,200.00	4,313,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	762,852,430.76	908,188,960.07
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	405,213,820.27	415,490,799.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	357,638,610.49	492,698,161.07
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	739,801,148.99	1,032,778,403.06
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	349,195,514.56	564,595,001.32
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	349,195,514.56	564,595,001.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	385,384,619.00	408,794,053.09
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	27,692,060.00	59,259,321.09
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	258,235,259.00	245,042,998.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	99,457,300.00	35,817,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	68,674,734.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,221,015.43	59,389,348.65
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,221,015.43	59,389,348.65
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	61,778,846.40	1,872,427,399.50
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	195,842,267.89	921,558,500.60
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	167,172,204.50	921,558,500.60
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	28,670,063.39	-
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН	(195,842,267.89)	(921,558,500.60)
5	НИЙТ ҮР ДҮН	(134,063,421.49)	950,868,898.90

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	3,355,094,370.30	4,755,746,155.48
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	11,666,270.30	17,160,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	11,666,270.30	17,160,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	11,666,270.30	17,160,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	11,666,270.30	17,160,200.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,343,428,100.00	4,738,585,955.48
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	3,343,428,100.00	4,113,366,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	3,343,428,100.00	4,113,366,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	595,684,725.48
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	336,684,725.48
131103	ЗГНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	239,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	20,000,000.00
1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих	-	29,535,130.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	-	29,535,130.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,348,881,270.30	4,745,746,155.48
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,348,881,270.30	4,670,685,369.48
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,598,311,581.31	3,257,962,291.94
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,320,184,721.31	1,725,902,500.00
210101	Үндсэн цалин	893,666,721.31	1,093,203,900.00
210102	Нэмэгдэл	258,078,700.00	463,639,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	168,439,300.00	169,059,300.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	158,306,200.00	215,737,800.00
210201	Тэтгэврийн даатгал	106,404,800.00	146,701,700.00
210202	Тэтгэмжийн даатгал	12,975,400.00	17,259,000.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,380,300.00	13,807,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,595,000.00	3,451,800.00
210205	Эрүүл мэндийн даатгал	25,950,700.00	34,518,100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	233,195,800.00	228,795,800.00
210301	Гэрэл, цахилгаан	94,932,300.00	103,897,300.00
210302	Түлш, халаалт	105,397,300.00	92,032,300.00
210303	Цэвэр, бохир ус	32,866,200.00	32,866,200.00
2104	Хангамж, бараа материалын зардал	70,357,360.00	101,053,820.93
210401	Бичиг хэрэг	20,950,300.00	34,024,400.00
210402	Тээвэр, шатахуун	20,840,300.00	37,808,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	27,623,360.00	28,277,320.93
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	943,400.00	943,400.00
2105	Нормативт зардал	269,300.00	269,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	269,300.00	269,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	18,980,900.00	111,582,814.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	7,858,700.00	1,172,000.00
210602	Тавилга	-	3,402,514.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	468,500.00	468,500.00
210604	Урсгал засвар	16,866,800.00	106,539,800.00
2107	Томилолт, зочны зардал	35,372,500.00	78,101,476.00
210701	Гадаад албан томилолт	-	6,522,968.00
210702	Дотоод албан томилолт	35,372,500.00	71,578,508.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	387,001,200.00	453,018,781.01
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	378,378,500.00	442,555,042.01

210803	Даатгалын үйлчилгээ	4,895,100.00	4,926,934.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	1,698,900.00	933,805.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	157,500.00	289,400.00
210807	Газрын төлбөр	1,871,200.00	4,313,600.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	374,643,600.00	343,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	374,643,600.00	343,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	750,569,688.99	1,412,723,077.54
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	349,195,514.56	564,595,001.32
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	349,195,514.56	564,595,001.32
2132	Бусад урсгал шилжүүлэг	396,153,159.00	486,249,920.09
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	29,535,130.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	32,315,600.00	63,049,321.09
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	264,380,259.00	277,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	99,457,300.00	35,817,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	80,848,469.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,221,015.43	361,878,156.13
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,221,015.43	361,878,156.13
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>6,213,100.00</u>	<u>85,060,786.00</u>
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=	<u>75,060,786.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	6,213,100.00	75,060,786.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	6,213,100.00	75,060,786.00
2200	Дотоод эх үүсвэрээр	6,213,100.00	75,060,786.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	6,213,100.00	75,060,786.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>(6,213,100.00)</u>	<u>(75,060,786.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	10,000,000.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	10,000,000.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,266,465,490.95	-	(179,616,587.91)	6,086,848,903.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	(982,924.79)	(982,924.79)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,266,465,490.95	-	(180,599,512.70)	6,085,865,978.25
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	1,950,814,240.89	-	1,950,814,240.89
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	252,038,980.00	-	-	252,038,980.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(134,063,421.49)	(134,063,421.49)
2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,518,504,470.95	1,950,814,240.89	(314,662,934.19)	8,154,655,777.65
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	704,537,933.83	704,537,933.83
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,518,504,470.95	1,950,814,240.89	389,874,999.64	8,859,193,711.48
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	178,062,412.00	-	178,062,412.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	950,868,898.90	950,868,898.90
2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,518,504,470.95	2,128,876,652.89	1,340,743,898.54	9,988,125,022.38

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/ төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,160,866,200.00	4,071,136,951.35	89,729,248.65	97.8
УРСГАЛ ЗАРДАЛ	4,160,866,200.00	4,071,136,951.35	89,729,248.65	97.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,097,482,500.00	3,049,827,159.94	47,655,340.06	98.5
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,725,902,500.00	1,725,902,500.00	00.00	100.0
Үндсэн цалин	1,093,203,900.00	1,093,203,900.00	00.00	100.0
Нэмэгдэл	463,639,300.00	463,639,300.00	00.00	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	169,059,300.00	169,059,300.00	00.00	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	215,737,800.00	215,737,800.00	00.00	100.0
Тэтгэврийн даатгал	146,701,700.00	146,701,700.00	00.00	100.0
Тэтгэмжийн даатгал	17,259,000.00	17,259,000.00	00.00	100.0
ҮОМШӨ-ний даатгал	13,807,200.00	13,807,200.00	00.00	100.0
Ажилгүйдлийн даатгал	3,451,800.00	3,451,800.00	00.00	100.0
Эрүүл мэндийн даатгал	34,518,100.00	34,518,100.00	00.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	228,795,800.00	228,795,800.00	00.00	100.0
Гэрэл, цахилгаан	103,897,300.00	103,897,300.00	00.00	100.0
Түлш, халаалт	92,032,300.00	92,032,300.00	00.00	100.0
Цэвэр, бохир ус	32,866,200.00	32,866,200.00	00.00	100.0
Хангамж, бараа материалын зардал	102,439,400.00	101,053,820.93	1,385,579.07	98.6
Бичиг хэрэг	34,024,400.00	34,024,400.00	00.00	100.0
Тээвэр, шатахуун	37,808,700.00	37,808,700.00	00.00	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	29,662,900.00	28,277,320.93	1,385,579.07	95.3
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	943,400.00	943,400.00	00.00	100.0
Нормативт зардал	269,300.00	269,300.00	00.00	100.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	269,300.00	269,300.00	00.00	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	180,643,600.00	180,643,600.00	00.00	100.0
Багаж, техник, хэрэгсэл	63,635,300.00	63,635,300.00	00.00	100.0
Тавилга	10,000,000.00	10,000,000.00	00.00	100.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	468,500.00	468,500.00	00.00	100.0
Урсгал засвар	106,539,800.00	106,539,800.00	00.00	100.0
Томилолт, зочны зардал	104,173,500.00	71,578,508.00	32,594,992.00	68.7
Дотоод албан томилолт	104,173,500.00	71,578,508.00	32,594,992.00	68.7
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	455,020,600.00	441,345,831.01	13,674,768.99	97.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	437,509,400.00	430,882,092.01	6,627,307.99	98.5
Даатгалын үйлчилгээ	4,926,900.00	4,926,934.00	-34.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	1,082,300.00	933,805.00	148,495.00	86.3
Тээврийн хэрэгслийн оношилгоо	699,000.00	289,400.00	409,600.00	41.4
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	6,000,000.00	-	6,000,000.00	00.0
Газрын төлбөр	4,803,000.00	4,313,600.00	489,400.00	89.8
Бараа үйлчилгээний бусад зардал	84,500,000.00	84,500,000.00	00.00	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	84,500,000.00	84,500,000.00	00.00	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,063,383,700.00	1,021,309,791.41	42,073,908.59	96.0
Засгийн газрын урсгал шилжүүлэг	571,460,200.00	564,595,001.32	6,865,198.68	98.8
Засгийн газрын гадаад шилжүүлэг	571,460,200.00	564,595,001.32	6,865,198.68	98.8

Бусад урсгал шилжүүлэг	491,923,500.00	456,714,790.09	35,208,709.91	92.8
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	68,850,800.00	63,049,321.09	5,801,478.91	91.6
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	277,000,000.00	277,000,000.00	00.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	64,470,700.00	35,817,000.00	28,653,700.00	55.6
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	81,602,000.00	80,848,469.00	753,531.00	99.1
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,160,866,200.00	4,071,136,951.35	89,729,248.65	97.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	4,113,366,100.00	4,053,976,751.35	59,389,348.65	98.6
Улсын төсвөөс санхүүжих	4,113,366,100.00	4,053,976,751.35	59,389,348.65	98.6
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	47,500,100.00	17,160,200.00	30,339,900.00	36.1
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	47,500,100.00	17,160,200.00	30,339,900.00	36.1
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	
АЖИЛЛАГСДЫН ТОО	108	98	10	90.7
Удирдах ажилтан	14	14	00	100.0
Гүйцэтгэх ажилтан	94	84	10	89.4

4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 1-р сарын 1-ны үлдэгдэл		-
ОРЛОГЫН ДҮН		595,684,725.48
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	336,684,725.48
ЗГНХ түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	239,000,000.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	20,000,000.00
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН		585,684,725.48
А.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН		283,195,918.00
1. Бараа үйлчилгээний зардал		283,195,918.00
1.3 Бараа үйлчилгээний бусад зардал		283,195,918.00
Гадаад албан томилолт	-	6,522,968.00
Бусад төсөл арга хэмжээ	-	17,672,950.00
Бараа үйлчилгээний бусад зардал	-	259,000,000.00
Татаас ба урсгал шилжүүлэг		302,488,807.48
Төвлөрүүлэх шилжүүлэг		302,488,807.48
Мөнгөн хөрөнгийн 2020 оны 12-р сарын 31-ны үлдэгдэл		10,000,000.00

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	2019 он	Аудитын нэр:	Санхүүгийн тайлангийн аудит	САГ-2020/189/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:		Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам		мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	Ажилтанд ажил хавсран гүйцэтгэсэн нэмэгдлийг 342.4 мянган төгрөгөөр илүү тооцож олгосон байна.	342.4	Зөвлөмж өгсөн	ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Т.Жамбалцэрэн Б.Ариунжаргал
2	2018 оны нийгмийн даатгалын шимтгэлийн тайлангаарх 210.3 мянган төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй.	-	Зөвлөмж өгсөн	Ахлах нягтлан бодогч	
3	Төсвийн орлогыг батлагдсан төсвөөс 30,339.9 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн.	30,339.9	Зөвлөмж өгсөн	ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч	Т.Жамбалцэрэн Б.Ариунжаргал
4	Үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй орон сууцны барилгын газрыг үнэлж бүртгээгүй.		Зөвлөмж өгсөн	Ахлах нягтлан бодогч	
5	Харилцах данснаас анхан шатны бүрдэл дутуу 3,821.7 мянган төгрөгийн баримтаар гүйлгээ хийж данс бүртгэлд тусгасан.	3,821.7	Зөвлөмж өгсөн	ТНБД-ын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ахлах нягтлан бодогч	Т.Жамбалцэрэн Б.Ариунжаргал
	Дүн	34,504.0			

